Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

| | | |
|---|---|---|
| Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/ | | |
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | | |
| *Тайлагнах хугацаа* | 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс | 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: Тэнгэр даатгал ХК, ҮЦК: TGI, | УБГД: 9017001018, Утас: 75001889 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж | |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Ердийн даатгалын үйл ажиллагаа | |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | Нексиа Глобал Монголиа Аудит ХХК | |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 60,000,000 ширхэг | |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Санхүүгийн тайлан бэлтгэсэн: О.Пүрэвжаргал, Хянасан: Б.Баянмөнх | |

| | | | |
|---|---|---|---|
| 1 | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт (мянган төгрөг)* | *Хөрөнгө* | |
| | | Мөнгөн хөрөнгө | 47,555,143 |
| | | Даатгалын хөрөнгө | 4,672,935 |
| | | Бусад хөрөнгө | 3,840,371 |
| | | **Нийт хөрөнгө** | **56,068,449** |
| | | *Өр төлбөр ба эздийн өмч* | |
| | | Даатгалын нөөц сан | 12,674,393 |
| | | Нөхөн төлбөрийн нөөц сан | 5,547,339 |
| | | Бусад өр төлбөр | 1,966,716 |
| | | Нийт эздийн өмч | 35,880,002 |
| | | **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **56,068,449** |
| | *Орлогын тайлан (мянган төгрөг)* | Даатгалын цэвэр хураамж | 20,398,743 |
| | | Орлогод тооцсон хураамж | 17,627,005 |
| | | Хөрөнгө оруулалтын орлого | 6,722,180 |
| | | Бусад орлого | 317,659 |
| | | Зардалд тооцсон нөхөн төлбөр | 7,071,103 |
| | | Үйл ажиллагааны зардал | 9,794,667 |
| | | Цэвэр ашиг | 7,165,756 |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)* | Хувьцаат капитал | 12,480,250 |
| | | Өмчийн бусад хэсэг | 1,023,322 |
| | | Хуримтлагдсан ашиг | 22,376,430 |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)* | Тайлан хавсаргав | |
| 1.1. | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | | |
| | "2024 оны 12 сарын 31-ний өдрөөр байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна" гэж дүгнэсэн байна. | | |

| | | |
|---|---|---|
| 2.5. | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл; | Зээлийн түүх байхгүй. |
| 3 | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | Тайлан хугацаанд гарсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-н тогтоолоор баталгаажуулж, Санхүүгийн зохицуулах хорооны холбоотой талын тайлан болон хөндлөнгийн аудитын "Холбоотой талууд" хэсэгт тусгасан болно. | |
| 4 | *Цалин урамшууллын мэдээлэл* | |
| | 2024 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинд 286.5 сая төгрөг, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 34.9 сая төгрөг тус тус гарсан байна. | |
| 5 | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |



**Засаглалын бүтэц, үйл ажиллагаа**

"Тэнгэр Даатгал" ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана.

Тэнгэр Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 6 ердийн гишүүн 3 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй сонгогдсон ба Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг орлон гүйцэтгэгч, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг тус тус сонгон ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын үүргийг орлон гүйцэтгэгч нь компанийн удирдлагын чиг үүрэг өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилладаг.

**Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 10:00 цагаас Тэнгэр Даатгал" ХК-ийн албан ёсны фейсбүүк www.facebook.com/tengerdaatgal хаягаар дамжуулан цахимаар хуралдсан. Хурлаас гаргасан шийдвэрийн танилцуулвал:

1. "Тэнгэр Даатгал" ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлав

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

**Ердийн гишүүд:**

**Ш.Гантуяа**
"Тэнгэр Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн дарга
Бизнесийн удирдлага мэргэжилтэй
"Мандал Санхүүгийн Нэгдэл"-ийн маркетинг хариуцсан захирал

**Т.Батзул**
"Мандал Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Бизнесийн удирдлага мэргэжилтэй

**Ж.Баатарболд**
"Си Эм Ай Академи" ХХК-ийн гүйцэтгэх захирал
Банкны удирдлага удирдлага мэргэжилтэй

**Д.Нямрэнцэн**
"Бүрэн" Групп-ын ТУЗ-ийн дарга
Эдийн засагч мэргэжилтэй

**Б.Батхишиг**
"Мандал Санхүүгийн Нэгдэл"-ийн гүйцэтгэх захирал
Бизнесийн эдийн засагч, Бизнесийн удирдлага мэргэжилтэй

**Г.Ганзориг**
"Мандал Капитал Маркетс" ҮЦК-ийн ерөнхий захирал
Бизнесийн удирдлага, эдийн засагч мэргэжилтэй

**Хараат бус гишүүд:**

**Ц.Түмэнцогт**
Монголын бизнесийн зөвлөл" ТББ-ийн удирдах зөвлөлийн дарга
Төрийн удирдлага мэргэжилтэй

**Ж.Далгэрсайхан**
Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн
Эдийн засагч, эрх зүйч мэргэжилтэй

**Г.Туул**
"Хас Банк"-ийн Экобанкны газрын захирал
Санхүү, бизнесийн удирдлага, нягтлан бодогч мэргэжилтэй

**ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ**

**Б.Баянмөнх**
Гүйцэтгэх захирал

**О.Батжаргал**
Эрсдэл хариуцсан захирал

**Г.Халиунаа**
Үйл ажиллагаа хариуцсан захирал

| 6 | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* |
|---|---|

"Тэнгэр Даатгал" ХК-ийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, бусад оролцогч талууд нь бидний бизнест үүсэх эрсдэлд шууд болон шууд бусаар өртөх боломжтой байдаг тул бидний зүгээс хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог алба, нэгж бүртээ бүрдүүлэн ажиллаж ирсэн. Бид байгууллагын соёлдоо ажилтан нэг бүр эрсдэлийн удирдлагад хариуцлагатай хандаж, өөрсдийн ажлын эрсдэл нэг бүрийг тооцоолон ажиллах хэв маягийг бүрдүүлж ажиллаж байна.

Компанийн эрсдэлийн бодлогын хүрээнд ТУЗ ба ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, багасгах арга хэмжээнүүдийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Аудит, эрсдэлийн хороо
2. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

ТУЗ-өөс Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлж, эрсдэлийг удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг баталж, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшинг тодорхойлох ба хэрэгжилтэд хяналт тавина. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

| 7 | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* |
|---|---|

| Хувьцаа эзэмшигчийн нэр | Хувьцаа эзэмшлийн хэмжээ |
|---|---|
| 1. "Мандал санхүүгийн нэгдэл" ХХК | 42.50% |
| 2. "Мандал праявит экүити ХОС" ХХК | 29.17% |
| 3. "Мандал ассет менежмент ҮЦК" ХХК | 3.75% |
| 4. "Мандал капитал маркетс ҮЦК" ХХК | 3.75% |
| 5. Олон нийт | 20.83% |
| **Хувьцаа эзэмшигчдийн тоо** | **1021** |




| 8 | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |
|---|---|

| № | Зарцуулалтын төрөл | Эзлэх хувь | Нийт дүн | Зарцуулалтын дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Борлуулалт дэмжих хөрөнгө оруулалт | 48% | 4,800,000,000 | 4,800,000,000 |
| 2 | Бусад хөрөнгө оруулалт | 21.6% | 2,160,000,000 | 649,750,000 |
| 3 | Сунгалтын систем болон аппликейшн хөгжүүлэлт | 8% | 800,000,000 | Ажил хийгдэж байна |
| 4 | Харилцагчдын боловсролын дэмжих маркетинг | 2.4% | 240,000,000 | Ажил хийгдэж байна |
| 5 | "Мандал праявит экүити хувийн ХОС" 2,500,000 ширхэг энгийн хувьцааны төлбөр | 20% | 2,000,000,000 | 2,000,000,000 |
| | **Нийт** | **100.0%** | **10,000,000,000** | |

| | |
|---|---|
| *9* | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | Тэнгэр даатгал ХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2 сарын 19-ний өдрийн BR 25/003 тогтоолын дагуу 2024 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 67.12(жаран долоон төгрөг арван хоёр мөнгө) төгрөг буюу 4,027,200,000(дөрвөн тэрбум хорин долоон сая хоёр зуун мянга) төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн. |
| *10* | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | "Тэнгэр Даатгал" ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд **eDOCTOR–** Монголын хамгийн анхны эрүүл мэндийн цогц платформ юм. Улс орны хувьд ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох нь нэн чухал асуудал байдаг. Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид бүх насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох цогц платформыг нэвтрүүлсэн билээ. **ASUUNA-** Өсвөр нас бол эрсдэлтэй зан үйлд татагдах хамгийн өндөр эрсдэлтэй үе байдаг тул энэ хугацаанд хүүхдийг үнэн зөв, баталгаатай, мэргэжлийн мэдээллээр хангах нь чухал юм. Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид 2022 оноос эхэлж ASUUNA платформыг хэрэглээнд нэвтрүүлээд байна. **ТЭНГЭР ТӨГӨЛ-** Бид 2021 онд нийт харилцагч, түншүүдтэйгээ хамтран мод тарьж, байнгын усалгаатай төгөл байгуулсан. Тодруулбал Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 га газарт өөрийн нэрэмжит Тэнгэр Төгөлийг байгуулж мод тарих, тохижуулах, усалгааны системийг нь бүрэн шийдэж, тарсан модны арчилгааг одоог хүртэл бүрэн хариуцан ажиллаж байна. |

*Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:*

*Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025/04/30*

Овог, нэр: Б.Баянмөнх

Албан тушаал: Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гарын үсэг: ………………………………………